



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

137 /137/


2021.09.17

ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД Б.БАЯРМАГНАЙ ОХУ-Д АЙЛЧЛАВ



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай тэргүүтэй төлөөлөгчид 9 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд ОХУ-д зохион байгуулагдсан "Запад-2021" Стратегийн команд штабын сургуулийн хаалтын ажиллагаанд оролцов. Арга хэмжээний үеэр Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай ОХУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд, хурандаа генерал А.В.Фоминтой танилцах уулзалт хийж, хоёр талын хамтын ажиллагааны зарим асуудлыг хэлэлцлээ. Мөн "Запад-2021" олон улсын стратегийн команд штабын сургуульд Зэвсэгт хүчний төлөөллүүдтэй мөр зэрэгцэн өндөр зохион байгуулалттай, сахилга баттай оролцсон хошууч генерал Л.Гансэлэм тэргүүтэй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийнханд баяр хүргэж, цаашдын ажилд нь амжилт хүсэв. Түүнчлэн Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Даваа төлөөлөгчдийг хүлээн авч, Элчин сайдын яамны үйл ажиллагаатай танилцуулсан байна.



ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах арга зүйн цугларалт явагдаж байна. Долоо хоногийн турш үргэлжлэх тус сургалтын үеэр удирдах бүрэлдэхүүн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, биеийн жингийн зохистой

харьцааны үзлэг, бие бялдрын түвшин тогтоох шалгалт өгөх юм. Үүний дараа "Байгууллагуудын хөгжлийн удирдлага", "Батлан хамгаалах салбарын шинжлэх ухаан, технологийн шинэчлэлийн талаар хэрэгжүүлж буй бодлого", "Дэвшилтэт технологи ба

зайн сургалт", "Цэргийн сургалт бэлтгэлийн орчны шинэчлэлийн үндсэн асуудлууд, хэрэгжилтийг хангах арга зам", "Зэвсэгт хүчний болон орон нутгийн цэргийн сургалт бэлтгэлийн уялдаа" зэрэг сэдвээр илтгэл сонсож бусад сургалтад хамрагдах аж.

Түүхэнд энэ өдөр

1937 он:

Ардын Сайд нарын зөвлөлийн 25 дугаар хурлын тогтоолоор МАХЦ-ийн ангиудын хамгаалж байсан Дорнод хязгаарыг ДЯЯ-ны хязгаарын цэрэгт шилжүүлэн хамгаалуулах болов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	☁️ 4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	☁️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,844.00	2,855.00
EUR 🇪🇺	3,339.0	3,393.0
CNY 🇨🇳	440.80	445.20
RUB 🇷🇺	38.80	40.50
JPY 🇯🇵	25.76	26.26
KRW 🇰🇷	2.36	2.49

ЗУРХАЙ

2021.09.17 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 11/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ЕСӨН УЛААН ШАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Эрхтэн хурц болно.

Наран ургах, шингих:

06.32-19.01

Барилдлага:

Шид

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал:

Ус

Аргын тооллын 9 дүгээр сарын 17, Сугар гараг. Билгийн тооллын 11, Булаагч одтой, шар луу өдөр. Өдрийн наран 06 цаг 32 минутад мандан, 19 цаг 01 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвиж эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвшил, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, этгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, хур оруулах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
260,281 +3234

ЭДГЭРСЭН
248,723 +4767

НАС БАРСАН
1042 +8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
4972 +84

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ
201

ЭДГЭРСЭН
4678

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 227,252,757

Эдгэрсэн

Нийт: 203,937,481

Нас барсан

Нийт: 4,673,481

Үйл явдал

“СЭЛЭНГЭ-2021”-Т МОТОБУУДЛАГЫН БАТАЛЬОН ОРОЛЦОНО




Монгол Улс, ОХУ-ын хамтарсан “Сэлэнгэ 2021” байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль 2021 оны 9 дүгээр сарын 19-нөөс 10 дугаар сарын 5-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Сургалтын төвийн районд “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд бэлтгэх, зохион байгуулж явуулах” сэдвээр явагдана.

Хамтарсан сургуулийн удирдагчаар Зэвсэгт хүчний ХЗЦК-ын штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр ажиллаж байгаа бөгөөд Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудаас хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын батальон оролцох юм.

ОХУ-ын талаас оролцох бүрэлдэхүүн тун удахгүй Монгол Улсад ирнэ.

Энэ өдөр

**БНМАУ-ЫН МАРШАЛ
Ю.ЦЭДЭНБАЛЫН 105 НАСНЫ
ОЙ ТОХИОЖ БАЙНА.**



ОРЧИН
ҮЕИЙН ХИЛ
ХАМГААЛАХ
БАЙГУУЛЛАГА
ҮҮСЭЖ
ХӨГЖСӨНИЙ 88
ЖИЛИЙН ОЙН
ӨДӨР.

"ЗАПАД-2021"-Т ТАКТИКИЙН БҮЛЭГ ОРОЛЦЛОО



ОХУ, БНБУ /Беларус-ын цэргийн 200 000 хүртэл алба хаагч, байлдааны онгоц болон нисдэг тэрэг 80 хүртэл, байлдааны усан онгоц 15, байлдааны 760 хүртэл нэгж /үүнээс 290 танк, тийрэлтэт артиллери 240 хүртэл/ оролцох хээрийн сургууль нь Беларусын 5 полигон, Оросын 9 полигон

дээр хоёр үе шаттайгаар явагдлаа. Монгол Улсын Зэвсэгт хүчин тактикийн бүлэг оролцож байгаагаар онцлогтой. Хятад, Вьетнам, Мьянма, Пакистан ажиглагчаар оролцож байгаа. Оросын Өрнөдийн цэргийн тойрог, Хойд далай, Балти, Хар тэнгисийн флотын салбар нэгжүүд хамрагджээ.



БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНИЙ СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт-шинжилгээ хариуцсан ахлах офицер, хурандаа М.Мөнгөтулга, Төлөвлөлт, сургалтын офицер, хошууч Ц.Энхтайван нарын албаны бүрэлдэхүүн энэ сарын

15-ны өдөр ангид ирж Сүхбаатар дүүргийн цэргийн I зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн мэргэжил олгох, давтан бэлтгэх сургалтад хамрагдаж буй алба хаагчдын сургалт, бэлтгэлийн үйл явцтай танилцлаа.

Энэ үеэр чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, цэргийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор алба

хаагчдын дунд ахлах ахлагч Б.Цэрэнбат Галын бэлтгэл хичээлийн нормативын тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд оролцсон алба хаагчдаас тэргүүн байрт бэлтгэл үүрэгтэн Д.Даваажамц, дэд байрт бэлтгэл үүрэгтэн Н.Мөнхбилгүүн нар шалгарч, өргөмжлөл, гарын бэлгээр шагнууллаа.

Номын санч Б.ЭНХТУЯА

АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛИЙН ЦОЛ ОЛГОЛОО



Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ЦДБЭЧ-ын Уран бүтээлийн хэлтсийн дарга-Ерөнхий найруулагч хошууч Б.Энхбаярт албан тушаалын зэрэглэлийн “Дэд хурандаа”, Бүжгийн албаны

дарга-Ерөнхий бүжиг дэглээч, ахмад Ш.Дамдинбазарт албан тушаалын зэрэглэлийн “Хошууч” цол олгогдсоныг ЦДБЭЧ-ын дарга хурандаа Г.Золзаяа гардуулан өглөө. Мөн Батлан хамгаалах яамны Төрийн нарийн

бичгийн даргын тушаалаар мэргэжлийн ур чадвараараа хамт олноо манлайлан ажиллаж буй Бүжгийн албаны бүжигчин, ахлагч Б.Отгончимэгийг “Гоцлол бүжигчин”-ээр, Найрал дууны албаны дуучин, ахлагч Г.Мөнхбат, дэд ахлагч М.Мөнх-Эрдэнэ нарыг “Гоцлол дуучин”-аар, ЦДБЭЧ-ын даргын тушаалаар Хөгжмийн албаны хөгжимчин В.Батболдыг “Гоцлол хөгжимчин”-өөр тус тус томилсныг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцууллаа.

Эрхэм хүндтэй бөгөөд хариуцлагатай цолны эзэд болж Монголын Зэвсэгт хүчин, Цэргийн чуулгынхаа хөгжилд дэвшилд үнэтэй хувь нэмрээ оруулан ажиллаж ирсэн та бүхэндээ ажлын өндөр амжилт хүсье!

“ОРОЛЦОО-2021”-Д ОРОЛЦОГЧДОД ГЭРЧИЛГЭЭ ГАРДУУЛЛАА

ҮБХИС-ийн хээрийн сургалтын төвд Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулсан “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо-2021” төслийн “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувийн ур чадварыг нь хөгжүүлэх цогц сургалт”-ын 1 дүгээр ээлж амжилттай зохион байгуулагдаж оролцогчдод гэрчилгээ гардууллаа.

Энэхүү арга хэмжээнд ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал, хурандаа Б.Өлзийхуяг, төслийн ерөнхий зохицуулагч, БХЯ-ны СБТГ-ын хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Энхсайхан, Хотхоны дарга, БХЭШХ-ийн Батлан хамгаалах дүн шинжилгээний төвийн дарга, доктор, хурандаа Л.Баатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн арга зүйч, сургалтын үйл ажиллагааны зохицуулагч, доктор Б.Түмэн-Өлзий, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборын ахлах арга зүйч, сургалтын соёл, спорт, чөлөөт цагийн үйл ажиллагааны зохицуулагч Т.Тунгалаг, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын сургалт, судалгаа, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, судалгааны багийн ахлагч Н.Лхагвадулам нарын оролцоо.

Төслийн сургалтын хотхоны дарга, хурандаа Л.Баатар сургалтын үйл ажиллагааны тайланг танилцуулж, сургалтад хамрагдсан нийт залуучуудыг төлөөлж Сэлэнгэ аймгийн



Шаамар сумаас оролцсон Б.Одцэцэг ая дуу өргөснөөр арга хэмжээ эхэлсэн юм.

Вакумжсан, тэтгэлэгт, 14 хоногийн хугацаатай цогц сургалтын 1 дүгээр ээлжид Өмнөговь, Дорноговь, Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Дундговь, Дорнод аймаг, Улаанбаатар хотын дүүргүүдээс ажил хийж амьдралаа өөрчлөх хүсэл зорилготой, өөртөө итгэлтэй, зорьсон зорилго, мөрөөдлөө биелүүлэх хүсэл эрмэлзлээр

дүүрэн, ирээдүйгээ цогцлоон бүтээж, эх орныхоо хөдөлмөрч, хариуцлагатай иргэн болохын төлөө зорьж буй 326 залуу хамрагдсан юм.

Оролцогчид сургалтын хугацаанд хөдөлмөрийн харилцаа, уламжлалт болон орчин үеийн соёлыг хослуулах, амьдралын зөв, эрүүл хэв маягт суралцах, хувь хүн, гэр бүл, хамт олны үнэ цэн гэсэн сэдэвчилсэн төрөл бүрийн сургалт, чөлөөт цагийн хөгжлийн хөтөлбөрүүдэд оролцож, харилцан суралцаж, хамтран хөдөлмөрлөхийн эрхэм харилцан суралцлаа.

Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисуудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)